



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/1348

Улаанбаатар хот

### Нийслэлийн хүүхдийн 35 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 14,494,757.48 (арван дөрвөн сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга долоон зуун тавин долоон төгрөг дөчин найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн хүүхдийн 35 дугаар цэцэрлэг (П.Лхагвасүрэн)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Хүүхдийн 281 дүгээр цэцэрлэг (Л.Цогзолмаа)-т, Нийслэлийн хүүхдийн 325 дугаар цэцэрлэг (О.Энхтуяа)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
 даргын 2025 оны 06 дүгээр сарын 10-ны  
 өдрийн 14/08 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	2-р хоолны тогоо 40л	11/28/2022	сайн	ш	1	5,000,000.00	5,000,000.00	1,854,166.66	3,145,833.34	Сүхбаатар дүүргийн 281 дүгээр цэцэрлэг
2	1-р хоолны тогоо	9/26/2022	сайн	ш	1	3,500,000.00	3,500,000.00	1,341,666.70	2,158,333.30	
3	Дээж хөргөгч	5/31/2018	сайн	ш	1	639,100.00	639,100.00	639,100.00	0.00	
4	Бэлтгэлийн ширээ	9/26/2022	сайн	ш	1	1,200,000.00	1,200,000.00	460,000.00	740,000.00	
<b>Машин тоног төхөөрөмжийн дүн</b>							<b>10,339,100.00</b>	<b>4,294,933.36</b>	<b>6,044,166.64</b>	
5	Хүүхдийн ширээ	9/30/2019	сайн	ш	7	43,909.64	307,367.48	181,859.05	125,508.43	Хан-Уул дүүргийн 325 дугаар цэцэрлэг
6	Хүүхдийн хувцасны шүүгээ	6/20/2023	сайн	ш	2	660,000.00	1,320,000.00	286,000.00	1,034,000.00	
7	Хүүхдийн сандал	5/31/2018	сайн	ш	80	23,300.00	1,864,000.00	1,351,400.23	512,599.77	
8	Хүүхдийн ширээ	9/30/2016	сайн	ш	10	66,429.00	664,290.00	592,325.25	71,964.75	
<b>Тавилга, эд хогшлын дүн</b>							<b>4,155,657.48</b>	<b>2,411,584.53</b>	<b>1,744,072.95</b>	
<b>Нийт балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн дүн дүн</b>							<b>14,494,757.48</b>	<b>6,706,517.89</b>	<b>7,788,239.59</b>	